

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

Уртнасангийн Цэрэндолгор

**Шилжилт хөдөлгөөн сэтгэцийн эрүүл
мэндэд нөлөөлөх нь**

ИНДЕКС: Е.720130. Сэтгэцийн эмгэг судлал

**Анагаах ухааны магистрын зэрэг
горилж бичсэн диссертаци**

Улаанбаатар хот
2006 он

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

Шилжилт хөдөлгөөн сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх нь
ИНДЕКС: E.720130. Сэтгэцийн эмгэг судлал

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

АУ-ны Доктор (Ph.D), дэд профессор Н.Орёл

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

АУ-ны Доктор (Ph.D), профессор С.Бямбасүрэн

Улаанбаатар хот
2006

Гарчиг

Судалгааны ажлын үндэслэл

Судалгааны ажлын зорилго

Судалгааны ажлын зорилт

Судалгааны ажлын шинэлэг тал

Судалгааны ажлын практик ач холбогдол

Судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлсэн байдал

Судалгааны ажлын бүтэц хэмжээ.....6

Хэвлэлийн тойм7

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн, аргачлал.....37

Судалгааны ажлын үр дүн.....39

Судалгааны ажлын хэлцэмж.....50

Судалгааны ажлын дүгнэлт.....53

Судалгааны ажлын практик зөвлөмж..... 53

Сэдэвтэй холбогдуулан хэвлүүлсэн материалууд....54

Товчилсон үгс.....55

Ном зүй.....56

Нэг. Удиртгал

Судалгааны ажлын үндэслэл

Сэтгэцийн эрүүл мэндийг бид тун удаан хайхралгүй явж ирсэн ба энэ нь хувь хүмүүс, нийгэм, цаашлаад улс орнуудын сайн сайхан, энх тунх байдалд онц чухал хэмээн ДЭМБ (2001) тунхаглаад байна. Сэтгэцийн эмгэгүүдийг илүү сайн танин мэдэх, илүү үр дүнтэй аргуудыг нэвтрүүлэх зорилгоор сэтгэцийн эрүүл мэндийг биологийн ба нийгэм, сэтгэлзүйн талаас нарийн судлах хэрэгтэй байна. Ийм эрдэм шинжилгээний ажлыг хийхдээ сэтгэцийн эмгэгүүдийн шалтгаан, явц, үр дагаварт нөлөөлж байгаа хүчин зүйлийг мэдэхийн тулд олон улсын түвшинд хийх хэрэгтэй гэж үзэх боллоо(15,20).

Сэтгэцийн эрүүл мэнд нь хувь хүний өөрийн болон гадаад олон хүчин зүйлээс хамаардаг. Удамшлын болон гэр бүлийн сэтгэцийн эмгэг удам дамжих боловч гадны хүчин зүйлийн нөлөөгөөр хэв шинж нь төлөвшин илэрдэг. Гэр бүл, хамт олны дунд зан үйлийн болон үйл ажиллагааны эмгэг бий болоход бухимдал тодорхой хувь нэмэр болдог. Өвдөх, ямар нэг юмнаас хагацах, ажилгүй болох, тэтгэвэрт гарах, эдийн засгийн хямралд орох, гэр бүлийн бэрхшээлтэй асуудлууд, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл салах зэрэг амьдралын зарим үйл явдлууд нийгмийн болон сэтгэл зүйн хувьд уналтанд ороход нөлөөлдгөөрөө нэг төрлийн эрсдэлт хүчин зүйл болдог бөгөөд эдгээрийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхөд анхаарах хэрэгтэй болоод байгаа юм (27,35).

Сэтгэл хөдлөл нь аливаа хүнд биеийн болон сэтгэл зүйн хувьд ямар нэг хариу урвал үүсгэдгээрээ бие болон сэтгэл зүйд их нөлөөтэй байдаг. Заримдаа бухимдал нь амьдралын бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд бэлтгэж өгдөг ч удаан үргэлжилбэл сэтгэл зүйн байдалд удаан хугацаагаар нөлөөлснөөр, хүний эрхтэн тогтолцооны үйл ажиллагааг алдагдуулах талтай байдаг. Үүний дүнд хувь хүн болон гэр бүлийн эрүүл мэндэд муугаар нөлөөлж болохуйц нийгмийн эмгэг үзэгдлүүд бий болдог байна(27,45,19).

ДЭМБ-ын судалгаагаар дэлхийд хөдөлмөрийн чадварыг гүнзгий алдагдуулдаг 10 өвчний 5 нь сэтгэцийн өвчин бөгөөд үүний нэг нь

шизофрени өвчин гэж тогтоожээ. Шизофрени өвчний үүсэх шалтгааныг дэлхий дахинаа одоог хүртэл бүрэн тогтоож чадаагүй учир „Онъсого мэт өвчин” гэж нэрлэсээр байгаа ба уг өвчин дэлхийн бүх оронд тархмал бөгөөд сэтгэцийн эмнэлэгт ирж буй нийт солиорлын хэлбэртэй өвчлөгсдийн 15-30%, хэвтэн эмчлүүлэгчдийн ихэнхи хувийг шизофрени өвчнөөр өвчлөгсөд эзэлдэг байна(4,7,11,15).

Судлаачид шизофрени өвчнөөр өвчлөгсөд нь цагаачдын дунд уугуул нутгийн иргэдээс илүү бөгөөд үүнийг шизофренийн эрсдэлт хүчин зүйл болохыг тайлбарлах оролдлого хийж байна(19,42,48,49,50,51).

Гадаадруу шилжилт хөдөлгөөн хийх нь стресс үүсгэдэг бөгөөд соёл иргэншлийн ялгаатай байдал, арьсны үзлийн нөлөө зэрэг нь шизофрени өвчнийг үүсгэхэд ихээхэн нөлөөлдөг юм гэж D.Burgo (2000)., K.Zolkowska (2001)., K.Ebata (2002) нарын эрдэмтэд тэмдэглэжээ. Мөн энэ асуудлаар эрдэмтэн Murphy (1977)., Malzberg, Lee (1956)., Cantor-Graae E., Pedersen C.B., McNeil T.F., Mortensen P.B (2003) нарын гол дүгнэлт нь цагаачлагчдийн дунд шизофрени өвчний тархалт өндөр байдаг гэж үзсэнийг соёл иргэншлийн огцом өөрчлөлтөнд орсонтой холбон тайлбарлах нь ч бас байна (19). Энэ сэдвээр олон улсын хурлууд зохион байгуулагдаж өөр соёл иргэншил бүхий орчинд шилжин очсон, эсвэл аж амьдрал, соёлын өөр хэв шинж түрэн орж байгаа орон зай цагт амьдарч байгаа хүмүүст „дасан зохицохуйн өөрчлөлт” зэрэг сэтгэцийн хамгийн хөнгөн өөрчлөлтөөс эхлээд төрөл бүрийн солиорол элбэгшдэг тухай дүгнэлтэнд хүрсээр байгаа юм(10).

Даяарчлалын эрин зуунд улс үндэстний өөр хоорондоо чөлөөтэй зорчих, амьдрах болсон өнөө үед бусад улс үндэстний соёл, шилжилт хөдөлгөөн хийхтэй холбоотой түүнээс үүсэх сэтгэцийн болон биемахбодийн өвчлөлийг судлах нь нийт судлаачдын өмнө ялангуяа сэтгэцийн эмгэг судлалын судлаачдын тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Судалгааны ажлын зорилго

Энэхүү судалгааны ажлын зорилго нь гадаад орнуудад шилжин амьдарч буй Монголчуудын сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тандан, өвчлөлийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг судлахад чиглэгдсэн юм.

Судалгааны ажлын зорилт

Судалгааны дээр дурдсан зорилгонд хүрэхийн тулд доорхи зорилтуудыг тавьж ажиллав. Үүнд:

1. Сэтгэцийн Эмгэг Клиникийн Эмнэлэгт шинээр хэвтэж эмчлүүлэгчдээс гадаад орнуудад ажиллаж, амьдарсантай холбоотой сэтгэцийн өвчин эхэлсэн буюу сэдэрсэн тохиолдлыг судлах.
2. Гадаадад амьдарч байгаад сэтгэцийн өвчнөөр өвчлөгсдөд тохиолдож буй зонхилох өвчнийг судлах.
3. Өвчинд нөлөөлж буй гол хүчин зүйлүүдийг тогтоон зөвлөмж боловсруулах.

Судалгааны шинэлэг тал

Манай оронд сэтгэцийн өвчин түүний дотроос ДШСӨ-д нөлөөлөх шилжилт хөдөлгөөнийг судалсан судалгаа урьд өмнө хийгдэж байгаагүй нь уг судалгааны ажлын шинэлэг тал оршиж байна.

Судалгааны ажлын практик ач холбогдол

Цагаачлал, шилжилтийн хүчин зүйл нь сэтгэцийн өвчлөлд хэрхэн нөлөөлж болох, өвчин эхэлсэн буюу сэдэрсэн үед зонхилон илрэх эмгэг, эмнэлзүйн онцлог, өвчин сэдээгч хүчин зүйлийг гадаадад амьдарч байгаад өвчилж ирсэн болон одоо ажиллаж буй хүмүүсийн хооронд харьцуулан судалсан бөгөөд өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулах явдал нь энэ судалгааны ажлын практик ач холбогдол оршино.

Судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлсэн байдал

1. ЭМШУИС-ийн Мэдрэл-сэтгэцийн эмгэг судлалын тэнхимийн 2003 оны 11 сарын 15-ны өдрийн хурлаар судалгааны ажлын сэдэв аргачлалыг хэлэлцүүлж батлуулсан / Протокол №34/.
2. Судалгааны ажлын үр дүнг 2005 оны 5-сарын 2-нд Мэдрэл-сэтгэцийн тэнхимын хурлаар хэлэлцүүлсэн / Протокол № 58/.
3. ЭМШУИС-ийн харъяа Дорноговь дахь АУК-ын Эрдмийн чуулган онол практикийн бага хуралд „Шилжилт сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нь.” сэдэвт илтгэл. 2004он.
4. ЭМЯ эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооны хурлын шийдвэрээр судалгаа хийх ёс зүйн зөвшөөрөл олгогдсон. 2004 оны 11-р сарын 3-ны өдөр. №04.
5. ЭМШУИС-ийн Био-Анагаахын ёс зүйн дүгнэлт гаргуулах хурлаар орж зөвшөөрөгдсөн болно. 2005 оны 05 сарын13-ны өдөр.
6. ЭМШУИС-ийн Анагаахын Ухааны Сургуулийн Эрдэмтдийн Зөвлөлөөр магистрийн урьдчилсан хамгаалалтыг хэлэлцүүлсэн хурал. 2005.06.24.

Судалгааны ажлын бүтэц, хэмжээ

Судалгааны ажлын бүтэц нь Монгол хэлээр бичигдсэн хуудас 59, хүснэгт 5, зураг 9-ийг багтаасан бүтээл болно. Энэхүү бүтээл нь удиртгал бүлэгтээ судалгааны ажлын үндэслэл, зорилго, зорилт, шинжлэх ухааны шинэлэг тал, судалгааны ажлын практик ач холбогдол, ажлын үр дүнг хэлэлцүүлсэн байдал, магистрийн ажлын бүтэц, хэмжээг багтаасан. Хоёрдугаар хэсэгт хэвлэлийн тойм, гуравдугаар бүлэгт судалгааны материал, арга зүй, дөрөвдүгээр бүлэгт судалгааны ажлын үр дүн, тавдугаар бүлэгт судалгааны ажлын үр дүнгийн хэлцэмж, зургадугаар бүлэгт дүгнэлт, практик зөвлөмж болон товчилсон үгийн тайлбар, хэвлэлд нийтлүүлсэн бүтээлийн жагсаалт, ашигласан хэвлэлийн жагсаалтууд багтсан болно.

Ном зүй

1. Бямбасүрэн С., Доржжадамба Ш. „Шүүхийн сэтгэц гэм судлал”.. Б.1990.Х.64-112.
2. Бямбасүрэн С., Ганхүү Г., Доржжадамба Ш., Дугаржав Ж., Бавуужав О., Доржханд Г. „Монгол улсын сэтгэцийн клиникийн эмнэлэгт хэвтэж эмчлүүлэгсдийн сэтгэцийн өвчлөлийн байдлын 60 жилийн хөдлөл зүйн үзүүлэлтүүд. /1933-1990 онуудад./ Монголын сэтгэцийн эмч нарын эрдэм шинжилгээний 12-р бага хурлын материал. I-дэвтэр. УБ.1994.х.11-20.
3. Бямбасүрэн С., Ганчулуун О., Лянхуа Д., Алтанцэцэг Я., Баасансүрэн Б., „Сэтгэцийн клиникийн эмнэлэгт анх удаа хэвтэж эмчлүүлсэн шизофрени тэй өвчтөнүүдийн сэтгэцийн байдалд хийсэн клиник статистикийн дүн шинжилгээ. Монголын сэтгэцийн эмч нарын эрдэм шинжилгээний 12-р бага хурлын материал. I-дэвтэр. УБ.1994.х.3-13.
4. Доржжадамба Ш. „Сэтгэцийн өвчнүүд “. УБ.1994.х.103-108.
5. Доржжадамба Ш. Монгол улсын хүн амын дундах сэтгэцийн өвчнийг бүртгэлийн аргаар судалсан байдал. / 1958-1993 он./ Хорьдугаар зууны үеийн монгол улс дахь сэтгэцийн эмгэгтйн тархалтын байдал. УБ.1996. х.23- 33.
6. Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар. Судалгааны тайлан. 2005.-х.15-42.
7. Орёл Н. „Шизофрени өвчний тархалт”. Хорьдугаар зууны үеийн монгол улс дахь сэтгэцийн эмгэгтйн тархалтын байдал. УБ.1996. 51-53.
8. Орёл Н., Доржжадамба Ш., Бямбасүрэн С. Сэтгэцийн эмгэгийн тархвар судлалын шинэчилсэн судалгааны ерөнхий дүн. /1991-1995 он/. Хорьдугаар зууны үеийн монгол улс дахь сэтгэцийн эмгэгийн тархалтын байдал. УБ.1996.х.34-45.
9. Орёл Н., Бямбасүрэн Б., Чимэдцэрэн Д., Цэеэнрэгзэн Н. Шизофрени өвчний эмнэл-тархвар судлалын судалгааг Дорнод аймагт хийсэн нь. Багш нарын эрдэм шинжилгээний 34-р бага хурлын илтгэлийн хураангуй. УБ. 1992.х. 105-106.

10. „Өнөөдөр” сонин. (сурвалжлагчийн асуултанд Н.Орёлын өгсөн хариулт). 2003,10,6. №233.
11. Хишигсүрэн З. Улаанбаатар хот дахь шизофренийн тархалт ба эмнэлзүйн байдалд хийсэн судалгаа. АУ-ны магистрийн зэрэг горилж бичсэн дипломын ажлын төсөл. УБ.1998.
12. Хүн амын шилжих хөдөлгөөний талаархи үндэсний дээд хэмжээний уулзалт. 2005.-х. 60.
13. Эрдэнэбаяр Л., Бямбасүрэн С., Аюушжав Б., Туяа Н. „ӨОУА- Х. Сэтгэцийн ба төрх үйлийн эмгэгүүдийн ангилал, эмнэлзүйн тодорхойлолт ба оношлолтын заавар”. 2004.
14. Энхбаатар Л. Сэтгэцийн гэм судлалын клиникийн эмнэлгийн зарим үзүүлэлтийн хандлагын асуудалд. Онош сэтгүүл. 2004.02.-с.18-19.
15. Сэтгэцийн эрүүл мэнд: Шинэ ойлголт, шинэ найдлага. ДЭМБ-ын тайлан. 2001.
16. Анжело Барбато. „Шизофрения”. Киев. 1998. –с.8; 17.
17. Бажина Б.А. „Шизофрения по данным отдаленного катамнеза”. П-1971.-с.70.
18. Гельдер М., Гет Д., Мейо Р. „Оксфордское руководство по психиатрии”. Том. I,II.К.:сфера, 1999.т.1-с 198-249.
19. Каплан Г.И., Сэдок А.Дж. „Клиническая психиатрия”. Том-1. М.:Медицина, 1994. с.232-290.
20. Каплан Г.И., Сэдок А.Дж. „Клиническая психиатрия”. М.:Медицина. 1983. –с.234-239.
21. Морозова Г.В. Руководство по психиатрии в 2х томах I. Под.ред.академика АМНСССР. М.:Медицина. В 2-х томах. Т-I. . М.:Медицина. 1988.-с.388-393.
22. Хоб Стобе. “АНУ, Герман дахь журмын бус шилжигчид: АНУ, Герман дахь нөхцөл байдал”. АНУ. 2000.
23. Полищук И.А. „Шизофрения”. К.: 1976. –с.32-36.
24. Семенов С.Ф. „Шизофрения”. К.: 1961. –с.32-65.
25. Снежневский А.В. „Шизофрения мультидисциплинарное исследование”. М.:Медицина. 1972.
26. Снежневский А.В. Руководство по психиатрии в 2х томах I. Под.ред.академика АМНСССР. М.:Медицина. 1983. –с.228-231.

27. Теодоре Х, Гулчински., Елена А, Варавикова. „Шинэ нийгмийн эрүүл мэнд. XXI зууны удиртгал” 2004. -х323-365.
28. Alfered M., Freedman M.D., Harold I, „Modern synopsis of comprehensive textbook of psychiatry II”. Baltimore. 1976. –с.433-436.
29. Alfered M., Freedman M.D., Harold I., Kaplan M.D. „Comprehensive textbook of psychiatry II”. Baltimore. 1967. –с.601-602.
30. Asarnow J.R. Children at risk for schizophrenia: converging lines of evidence. Schizophrenia bulletin. 1988. 14: 613-631.
31. Cade J. F J; Krupinski J. Incidence of psychiatric disorders in Victoria in relation to country of birth. Medical journal of Australia, 1962. 49: 400-404.
32. Cochrane R. Mental illness in immigrants to England and Wales: an analysis of mental hospital admissions, 1971. Sociol psychiatry, 1977. 12: 25-35.
33. Dunham H.W. (1965). Community and Schizophrenia; an epidemiological analysis. Detroit Wayne state University Press.
34. Dunham H.W. Epidemiology of psychiatric disorder as a contribution to medicine. Inc. j. psychiat., 1968.5,2.
35. Eaton W,W. Epidemiology of schizophrenia. Epidemiologic Reviews, 1985.7:105-125.
36. Essen-Moller E. Individual traits and morbidity in a Swedish rural population. Acta psychiatrica et neurologica scandinavica, 1956. 100: /Suppl./; 1-160.
37. Faris REL, Dunham H.W. (1939), Mental disorder in urban areas, an ecological study of schizophrenia and other psychoses. Chicago, University of Chicago Press.
38. Gupta S. Can environmental factors explain the epidemiology of schizophrenia in immigrant groups? Social psychiatry and psychiatric epidemiology. 1993. 28: 263-266.
39. Halevi HS. Frequency of mental illness among Jews in Israel. International journal of social psychiatry. 9: 268-282.
40. Hollingshead A.B, Redlich E.C. (1958). Social class and mental illness. New York, Wiley.

41. Jablensky. A. et al (1992). Schizophrenia: manifestations insidens and cours in different cultures. A World Health Organization ten – country ctudy. Psychological medicine, Suppl. 20.
42. Malzberg B. Are immigrants psychologically disturbed? In: plog SC, Edgerton RB, eds. Changing perspetives in mental illnes, New York, Holt, Rinehart, Wiston, pp. 1969. 395-421.
43. Norman MG; Malla AK. „, Stress life event and Schizophrenia. I: A review of the research”. British journal of psychiatry, 1993.c.162: 161-166.
44. Sandhaus S. Migrant healt: A harvest of proverty. American Journal of Nursing, 1998.52-54.
45. Stop exclusion Dare to care. World Health Day. 2001. World Health Organization.
46. Warner R. Recovery from schizophrenia: psychiatry and polytical economy. London, Routledge, Kegan Paul. 1985.
47. Warner. R; G. de Girolomo. „, Шизофрения ”. Эпидемиология психических расстройств и психосоциальных проблем. ВОЗ. Женева. 1996.
48. <http://www.ncbi.nlm.gov/> Cantor-Graae E., Pedersen C.B., McNeil T.F., Mortensen P.B. „,Migration as a risk factor for schizophrenia: a Danish population-based cohort study”. Br J Psychiatry. 2003 Feb;182:117-22.
49. <http://www.ncbi.nlm.gov/> Zolkowska K., Cantor-Graae E., McNeil T.F. „,Increased rate of psychosis among immigrants to Sweden: is migration a risc factor for psychosis?”. Psychol Med. 2001 May;31(4):669-78.
50. <http://www.ncbi.nlm.gov/> Bhurgo D. „,Migration and schizophrenia”. Acta psychiatr Scand Suppl. 2000;102 (407):68-73.
51. <http://www.ncbi.nlm.gov/> Ebata K. „,Cross-cultural adaptation and mental disorder”. Seishin Shinkeigaku Zasshi. 2002;104(4):278-91.
52. <http://www.ncbi.nlm.gov/> Rabinowitz J., Fenneg S. „,Differences in ago of first hospitalization for schizophrenia among immigrants and nonimmigrants in a national case registry”. Schizophr Bull. 2002;28(3);49-9.
53. <mailto:webmaster@vtpu.org.au> Barbara R., Ferguson. „,Migration and Mental Health”. 2003.Feb10.

54. <http://www>. Kim K, Hwu H, Zhang LD, Lu MK, Park KK, Hwang TJ, Kim D, Park YC. „Schizophrenic delusions in Seoul, Shanghai and Taipei: a transcultural study”. J Korean Me; Sci. 2001. Feb;16(1):88-94.
55. <http://www> Richard Warner. Schizophrenia Bulletin. Vol.21.No.3.1995.
56. <http://www> Moldavsky D., „The implication of transcultural psychiatry for clinical practice”. Isr J Psychiatry Relat Sci. 2003;40(1):47-56.
57. <http://www> Kukhara P., „Outcome of schizophrenia: some transcultural observations with particular reference developing countries”. Eur Arch Psychiatry Clin Neurosci. 1994;244(5):227-35.
58. WWW.immigrationaid.com, www.immigration-usa.com
АНУ.Шилжин ирэгчдэд үзүүлэх үйлчилгээ.
59. Migrant health, <http://www.aap.org/policy?andhttp:bphc.hrsa.gov>
60. World Health Organization, Mental Health Program,
<http://www.who.int/msa/>
61. NIMH интернет <http://www.nimf.gov>
62. http://www.bphc.hrsa.dhhs.gov/uhsc/Page/about_nhsc/3D1b_migrant.htm
[w](#)